



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн  
ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

**Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус  
аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь, Монголын цахилгаан холбоо ХК-ийн Дүрмийн 7.8.7 дахь заалт 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:

1.1. Нийт хөрөнгийг 40,876,412,194.13 (дөчин тэрбум найман зуун далан зургаан сая дөрвөн зуун арван хоёр мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг арван гурван мөнгө) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 26,698,568,709.51 (хорин зургаан тэрбум зургаан зуун ерэн найман сая таван зуун жаран найман мянга долоон зуун есөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгөөр;

1.2. Өр төлбөрийн нийт дүнг 7,210,177,824.42 (долоон тэрбум хоёр зуун арван сая нэг зуун далан долоон мянга найман зуун хорин дөрвөн төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгөөр;

1.3. Эзэмшигчийн өмчийг 33,666,234,369.71 (гучин гурван тэрбум зургаан зуун жаран зургаан сая хоёр зуун гучин дөрвөн мянга гурван зуун жаран есөн төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх  
дүгнэлтийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, 96 дугаар зүйлийн 96.4 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн 2019 оны зардлын төсвийг батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг Хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, гишүүдийн цалинг тэдний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



### ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв

	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
<b>1. Цалин, холбоо, тээврийн зардал</b>					
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	550,000	12	59,400,000
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	350,000	12	4,200,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	150,000	12	1,800,000
	<b>Цалин, холбоо, тээврийн зардлын дүн</b>				<b>65,400,000</b>
<b>2. Бичиг хэрэг, хурлын зардал</b>					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал		125,000	12	1,500,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс		200,000	6	1,200,000
3	Бусад зардал		115,000	6	690,000
	<b>Бичиг хэрэг, хурлын зардлын дүн</b>				<b>3,390,000</b>
<b>3. МТХХ-ны салбарын хурал, үзэсгэлэн, форумд оролцох, салбарын туршлага судлах, сургалтын зардал</b>					
	<b>МТХХ-ны салбарын хурал, үзэсгэлэн, форумд оролцох томилолт</b>				<b>13,950,000</b>
1	Тээврийн зардал	6	1,800,000	1	10,800,000
	Зам хоног	6	150,000	1	900,000
	Зочид буудал	6	375,000	1	2,250,000
	<b>Мэдээлэл харилцаа холбоо, технологийн салбарын туршлага судлах, сургалт</b>				<b>15,900,000</b>
2	Тээврийн зардал	4	1,800,000	1	7,200,000
	Зам хоног	4	175,000	1	700,000
	Зочид буудал /4 өдөр/	4	2,000,000	1	8,000,000
	<b>Томилолт, сургалтын зардлын дүн</b>				<b>29,850,000</b>
	<b>Нийт дүн</b>				<b>98,640,000</b>